



СОЙМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№222 /431/

2022.12.09

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ХӨДӨЛГӨӨНТ ЭМНЭЛЭГ 9000 КМ ГАРУЙ ЗАМ ТУУЛЖ, 5500 ГАРУЙ ИРГЭНИЙГ ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ҮЗЛЭГ, ОНОШИЛГООНД ХАМРУУЛЛАА


Энэ оны тавдугаар сарын 1-ний өдрөөс орон даяар хэрэгжиж эхэлсэн халдварт болон хавдрын өвчнийг илрүүлэх "Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо"-ны ажилд Цэргийн төв эмнэлэг суурин болон хөдөлгөөнт байдлаар оролцож, хүн ардынхаа эрүүл мэндийн үйл хэрэгт хүчин зүтгэлээ.

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб болон төрлийн цэргийн командлалуудын цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу цэрэгжилтийн спортын төмцээн уралдаанд оролцох баг тамирчид, гадаад оронд сургуульд суралцах цэргийн алба хаагчид болон сонсогч нар, НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн алба хаагчид, ҮБХИС-д шинээр элсэн суралцагч сонсогч нарт хийгдэх ёстой төлөвлөгөөт эрүүл мэндийн урьдчилан



сэргийлэх үзлэгийг өнгөрсөн 5, 6, 7 дугаар саруудад хийсэн байна. Мөнравдугаар сард БХЯ, ЗХЖШ-ын бие бүрэлдэхүүнийг үзлэг шинжилгээнд хамруулсан төдийгүй Улаанбаатар цэргийн хүрээний зарим анги нэгтгэл, БЗД-ийн энгийн иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулжээ. Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт үзлэгийн баг нь: • 5 болон 6 дугаар саруудад Төв аймаг, Дорноговь аймгуудад ажиллаж амьдарч байгаа цэргийн алба хаагчид, тэдгээрийн ар гэр,

энгийн иргэдэд, • 8 дугаар сарын 8-наас 9 дүгээр сарын 20-ны хооронд төвийн бүсийн Өвөрхангай Баянхонгор, баруун бүсийн Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Завхан аймгууд болон хойд бүсийн Булган, Орхон, Дархан-Уул аймгууд дахь Зэвсэгт хүчний анги салбаруудад алба хааж буй цэргийн алба хаагчид, тэдгээрийн ар гэр, чөлөөнд гарсан ахмадуудад болон энгийн иргэдэд, • 10 дугаар сарын 5-ны өдрөөс 10 дугаар сарын 13-ны хооронд



Архангай аймгийн Жаргалант сумын иргэдэд, • 11 дүгээр сард Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг болон Рашаант сумын 800 орчим иргэдэд эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийсэн байна. Энэ хугацаанд хөдөлгөөнт үзлэгийн баг дээрхи аймаг сумдын нутгаар нийт 9000 км гаруй зам туулж, суурин болон хөдөлгөөнд байдлаар 5500 гаруй иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн

зөвлөгөө өгчээ. Үзлэг оношилгоонд хамрагдсан иргэдэд дараах өвчлөл зонхилж байна. Үүнд: • Ходоод 12 нугалаа гэдэсний шархлаат үрэвсэл, ходоодны архаг болон хурц үрэвсэл нийт илэрсэн өвчлөлийн 14,8% • Элэгний вирусийн шалтгаант үрэвсэл нийт илэрсэн өвчлөлийн 11% • Артерийн даралт ихсэх өвчин нийт илэрсэн өвчлөлийн 9,8% • Бүсэлхий нуруу орчмын мэдрэлийн ёзоорын өвдөлт нийт илэрсэн өвчлөлийн 6,2% • Зүрхний хэм алдагдал болон дамжуулалтын хориг бүхий эмгэгүүд нийт илэрсэн өвчлөлийн 2,3% тус тус тохиолдсон байна. Хөдөлгөөнт үзлэгийн баг цаашид зүүн болон өмнөд бүсийн аймгуудад үзлэг шинжилгээг үргэлжлүүлнэ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-17	-29

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.442	3.445
EUR	3.655	3.670
CNY	492	495
RUB	52.30	53.20
JPY	25.30	25.55
KRW	2.65	2.68

ЗУРХАЙ



ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН ГАХАЙ САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:
Өвчин ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.26-16.59
Барилдлага:
Үл тохирох
Шүтэн барилдлага:
Төрөхүй

ХУРАНДАА Т.ГАЛБАДРАХ ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ ХАНДИВЛАЛАА



БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Мотобуудлагын 12 дугаар ээлжийн бие бүрэлдэхүүнд ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрахын гэр бүлийн зүгээс ажиллагааны газар оронд ашиглагдаж, хуучирч он цагийн элэгдэлд орсон хөгжмийн зэмсгүүдийг шинэчлэх зорилгоор таван сая төгрөгийн үнэ бүхий цахилгаан хөгжмийн зэмсгийг хандивлалаа.

Тэрбээр хэлсэн үгэндээ, "Бүтэн жилийн хугацаанд эх орноосоо алс хол дэлхийн энхтайвны төлөө албан үүргээ гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүнд чөлөөт цагаа зөв боловсон, соёлтой өнгөрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх юмсан хэмээн бодож, мөрөөдөж явсан минь өнөөдөр биеллээ оллоо. Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын хамгийн залуу гишүүн орны хувьд тусламж хэрэгтэй газар оронд залуус маань хэрхэн ажиллаж нэгдэн



нийлж чаддаг вэ гэдгийг харуулж, илүү эрч хүчтэй үлгэр жишээч байхыг хүсье" хэмээгээд хөгжмийн зэмсгийг Мотобуудлагын 12 дугаар ээлжийн батальоны сургалт соёл хүмүүжил эрхэлсэн орлогч дэд хурандаа П.Энхтайван болон соёл хүмүүжлийн офицер ахмад О.Ичинноров нарт гардуулан өгсөн юм.

Х.УНДАРМАА



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 652,237,226
Эдгэрсэн Нийт: 628,229,779
Нас барсан Нийт: 6,654,373

